



Өгөгдлийг нүдэн дотор багтааж, байрлуулах аргууд





Хэрэв текстэн өгөгдөл нүдэн дотроо багтахгүй урт байвал тухайн текстийг агуулж буй баганых нь өргөнийг сунгах замаар багтааж болдог. Гэтэл хүснэгт байгуулж байх үед хүснэгтийн толгойн гарчиг нь урт боловч тухайн багананд орох тоон өгөгдлүүд нь тийм ч урт биш байвал баганы өргөнийг нь сунгаж багтаах нь тохиромжгүй байдаг. Харин тийм текстийг нүдэнд “нугалж” эсвэл “тодорхой өнцгөөр эргүүлж” багтаах нь хамгийн тохиромжтой байдаг.

Home [Үндсэн] табын **Alignment [Тэгшлэх]** бүлгийн командуудаар нүдний өгөгдлийг хүссэн байрлалаар байрлуулж, эргүүлж, нугалж болно. **Alignment [Тэгшлэх]** бүлгийн баруун доод буланд байрлах сумтай  товчин дээр дарахад **Alignment [Тэгшлэх]** харилцах цонх нээгдэнэ.






Энэ харилцах цонх нь доорх бүлэг команд, сонголтуудыг агуулж байдаг. Үүнд: **Text Alignment [Текстийг зэрэгцүүлэх]** бүлгийн командууд нь өгөгдлийг нүдний өргөн ба өндрийнх нь хувьд тэгшилнэ.


Horizontal [Хөндлөн] бүлгийн командууд нь нүдний өгөгдлийг нүдний өргөнийх нь хувьд буюу баруун ба зүүн талтай нь тэгшилнэ.



General [Үндсэн]	Өгөгдлийг хөндлөн байрлалд тэгшлэх стандарт горим. Текстийг нүдний зүүн тал руу, тоог нүдний баруун талтай тэгшилж байрлуулна.
Left [Зүүн]	Home [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Өгөгдлийг нүдний зүүн талтай тэгшилнэ.
Center [Голлуулах]	Home [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Өгөгдлийг нүдэнд голлуулна.
Right [Баруун]	Home [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Өгөгдлийг нүдний баруун талтай тэгшилнэ.
Fill [Бөглөх]	Өгөгдлийг нүд эсвэл нүдний мужид нь багтах тоогоор давтана.
Justify [Тарааж тэгшлэх]	Нүдний өгөгдөл нүдний зүүн ба баруун тал руу тэгш тараагдаж байрлана.
Center Across Selection [Ялгасан голлуулах] [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Нүдний мужийн хамгийн зүүн талын нүдний өгөгдлийг сонгож ялгасан нүднүүдийн голд байрлуулна.	
Indent [Догол]	Өгөгдсөн хэмжээгээр өгөгдлийг нүдний зүүн эсвэл баруун талаас доголтой болгоно.

Vertical [Босоо] бүлгийн командууд нүдний өгөгдлийг нүдний өндөрт нь буюу дээд доод тал руу нь тэгшилнэ.


Top [Дээд тал]	Home [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Өгөгдлийг нүдний дээд тал руу тэгшилнэ.
Center [Голлуулах]	Home [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Өгөгдлийг нүдний өндөрт голлуулна.
Bottom [Доод тал]	Home [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Өгөгдлийг нүдний доод талд байрлуулна.
Justify [Тарааж тэгшлэх]	Нүдний өгөгдөл нүдний дээд ба доод тал руу тэгш тараагдаж байрлана.

Text Control [Текстийг удирдах] бүлгийн хяналтын товчнууд нь идэвхтэй байх үедээ дараах өөрчлөлтүүдийг нүдэнд хийнэ.

Wrap Text [Текст нугалах]	Home [Үндсэн] табын Alignment [Тэгшлэх] бүлгийн  товч. Нүдэн дэх урт текстэн өгөгдлийг нүдэнд багтгал нь хэд хэдэн мөр болгон нугална.
Shrink to fit [Багтгал нь шахах]	Өгөгдлийг нүдэнд багтгал нь шахаж хураангуйлна.
Merge Cells [Нүднүүдийг нэгтгэх]	Хоёр ба түүнээс дээш тооны нүдийг нэгтгэж нэг нүд болгоно.

Alignment [Тэгшлэх] бүлгийн  товчны хажуугийн  товчин дээр дарахад доорх командууд гарч ирнэ. Үүнд:

- **Merge & Center** – Нүднүүдийг нэгтгээд, өгөгдлийг нь голлуулна.
- **Merge Across** – Нүднүүдийг мөрийн дагуу нэгтгэнэ.
- **Merge Cells** – Нүднүүдийг мөр болон баганы дагуу нэгтгэнэ.
- **Unmerge Cells** – Нэгтгэсэн нүднүүдийг буцааж салгана.

Orientation [Байршуулалт] бүлгийн цонхон доторх сонголтууд нь текстийг тодорхой өнцгөөр эргүүлэх, тэмдэгтүүдийг дээрээс нь доош цувуулж байрлуулах боломж олгоно. **Home** [Үндсэн] табын **Alignment** [Тэгшлэх] бүлгийн  товчоор дуудна.